



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/201

Алтай хот

Агентлаг, сумуудын ажил дүгнэх  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын 10.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Сумдын 2022 оны үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээгээр нэгдүгээрт эрэмбэлэгдсэн Цогт сумын Засаг даргын Тамгын газрыг 3,000,000 (гурван сая), хоёрдугаарт эрэмбэлэгдсэн Цээл, Эрдэнэ сумдын Засаг даргын Тамгын газрыг тус бүр 2,000,000 (хоёр сая), гуравдугаарт эрэмбэлэгдсэн Тонхил, Алтай сумдын Засаг даргын Тамгын газрыг тус бүр 1,000,000 (нэг сая) төгрөгөөр тус тус урамшуулсугай.

2.Агентлагийн 2022 оны үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээгээр нэгдүгээрт эрэмбэлэгдсэн Боловсрол, шинжлэх ухааны газрыг 2,000,000 (хоёр сая), хоёрдугаарт эрэмбэлэгдсэн Эрүүл мэндийн газрыг 1,500,000 (нэг сая таван зуун мянга), гуравдугаарт эрэмбэлэгдсэн Биеийн тамир, спортын газрыг 1,000,000 (нэг сая) төгрөгөөр тус тус урамшуулсугай.

3.Урамшуулалд зарцуулагдах 13,500,000 (арван гурван сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР